



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/127

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчлигээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1. дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын жагсаалтын 2.21-д тусгагдсан “Зүүн хаалганы намагжилтыг багасгах ажил /Жаргалант сум, Цамбагарав, Рашаант, Наран баг/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: П.Мягмартүвшин - Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны байцаагч

Н.Отгонбаяр - Иргэний төлөөлөл

Ж.Ганболд - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Э.Цолмон - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлж, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Цогтбаяр/-нд даалгасугай.

3. Дээрхи төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Э.Цолмон/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02.00783  
D/Tush-A/127-Bo